



Лабораторийн шинжилгээнд хэрхэн бэлдэх вэ?

Цусны болон биохимийн шинжилгээнд бэлтгэх

- ✓ Судасны цусыг өглөө өлөн байх үед авах нь зохимжтой
- ✓ Цус өгөхөөс өмнө үйлчлүүлэгч 15 минут орчим тайван байна.
- ✓ Шинжилгээний өмнөх өдөр архи, тамхи хэрэглээгүй, биеийн хүчний дасгал хийгээгүй байх.
- ✓ 19:00 цагаас хойш өөх тостой хоол идээгүй байна.
- ✓ Сахар, өөх тос, нойр булчирхайн шинжилгээнд 12 цаг зайлшгүй өлөн байх шаардлагатай.

Шээсний шинжилгээнд бэлтгэх

- ✓ Шээсийг зориулалтын нэг удаагийн ариун саванд /цэвэр өнгөгүй, тунгалаг цэвэрлэж угаасан, том амсартай таглаатай шилэн сав/ хийж авчирч өгнө.
- ✓ Шинжилгээ өгөхийн өмнө гадна бэлэг эрхтнээ сайтар угаасан байх хэрэгтэй.
- ✓ Шээсний шинжилгээ өгөхийн өмнө шээсний өнгөнд өөрчлөлт өгдөг хоол хүнс хэрэглэж болохгүй.
- ✓ Шээсний шинжилгээний сорьцийг өглөөний өлөн шээсний дунд хэсгээс зориулалтын савны $\frac{1}{2}$ (100-200мл) орчим шээс тосож авна.
- ✓ Шаардлагатай тохиолдолд 2-3 цагийн шээсний сорьц авч болно.
- ✓ Шээсний ерөнхий шинжилгээний сорьцийг авснаас хойш 2 цагийн дотор лабораторит аль болох хурдан хүргэнэ.
- ✓ Хөлдөөж болохгүй.

Нөлөөлөх хүчин зүйл:

Шээсний шинжилгээ өгөхийн урд өдөр улаан манжин зэрэг будагч бодистой хүнс болон шоколад, кофе, сироп зэрэг хэт чихэрлэг зүйлийг хэрэглээгүй байх шаардлагатай.

Өлөн шээснээс шинжилгээ авах ба түүний дунд гуравны нэгээс таслан авна /эхлэл болон төгсгөлийн шээсийг авахгүй/.